

# АРД КАПИТАЛ ГРУПП ХХК

## ДАНС НЭЭЛГЭХ БОЛОН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЗӨВЛӨМЖ

Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцохдоо биднийг сонгож үйлчлүүлэх болсон танд баярлалаа. Бид бүхэн танд хамгийн найдвартай бөгөөд чанартай үйлчилгээг үзүүлэхийг зорьж ажиллах болно.

Та данс нээлгэх болон арилжаанд оролцохдоо дараах зөвлөмжийг дагана уу.

### Данс нээх

Аж ахуй нэгж байгууллага нь үнэт цаасны болон бэлэн мөнгөний төлбөр тооцооны гэсэн 2 данс нээлгэх юм.

- Үнэт цаасны данс нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ) дээр нээгдэх ба дараах материалыг бүрдүүлнэ:
  - Данс нээлгэх хүсэлт /ҮЦТХТөвд хаягласан/
  - Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний хуулбар / нотариатаар баталгаажсан /
  - ҮЦТХТ – ийн данс нээлгэх маягт
  - Хуулийн этгээдийн данс дах хөрөнгийн захиран зарцуулах этгээдийг томилсон тухай компанийн ТУЗ эсхүл ХНХ-ийн шийдвэр
  - Төвлөрсөн хадгаламжийн данс дах хөрөнгийн захиран зарцуулах эрх бүхий этгээд, албан тушаалтны овог нэр, төлбөр тооцооны баримтанд зурах нотариатаар гэрчлэгдсэн гарын үсгийн маягт /ҮЦТХТөв ХХК-аас баталсан хэвлэмэл маягтын дагуу гарын үсгийг баталгааг гаргаж өгнө/
  - Данс захиран зарцуулагчийн иргэний үнэмлэхийн хуулбар
  - Данс нээлгэх хураамж 50,000 төг
- Төлбөр тооцооны данс нээлгэхийн тулд Ард капитал групп, Худалдаа хөгжлийн банк, харилцагчийн хооронд гурвалсан гэрээ байгуулна. Харилцагч үнэт цаас худалдах, худалдан авахдаа энэхүү дансаар бэлэн мөнгөний төлбөр тооцоо гүйцэтгэх юм.

Төлбөр тооцооны дансыг Худалдаа хөгжлийн банк дээр нээх ба дараах материалыг бүрдүүлнэ:

1. Данс нээлгэх хүсэлт / ХХБ хаягласан /
2. ХХБ – ны данс нээлгэх маягт
3. Данс нээх гэрээ
4. Харилцагчийн дэлгэрэнгүй мэдээллийн анкет /ХХБ-ны маягт/
5. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажсан /
6. Компанийн дурэм
7. Хуулийн этгээдийн данс дах хөрөнгийн захиран зарцуулах этгээдийг томилсон тухай компанийн ТҮЗ-д эсхүл ХНХ-ийн шийдвэр
8. Төлбөр тооцооны данс дах хөрөнгийн захиран зарцуулах эрх бүхий этгээд, албан тушаалтны овог нэр, төлбөр тооцооны баримтанд зурах нотариатаар гэрчлэгдсэн гарын үсгийн маягт / ХХБ маягт /
9. Данс захиран зарцуулагчийн иргэний үнэмлэхний хуулбар

### **Дансандаа мөнгө байршуулах**

Бид танд дансны дугаар олгосны дараагаар та дансандаа мөнгө байршуулах боломжтой болно.

Та Монголоос болон дэлхийн аль ч улсаас үнэт цаасны арилжааны дансандаа мөнгө байршуулах боломжтой.

Дансны нэр: *Харилцагчийн нэр*

Дансны дугаар: *Үнэт цаасны төлбөр тооцооны дансны дугаар*

Банкны нэр: Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ)

Банкны хаяг: Худалдаа Хөгжлийн Банк, Улаанбаатар хот, Монгол Улс

Свифт код: TDBMMNUB

Гүйлгээний Утга: Хувьцааны мөнгө

Хэрвээ дамжуулагч банкаар гүйлгээ хийгдэх шаардлагатай бол дараах 3 банкыг сонгоно уу.

**1. CITIBANK N.A, NEW YORK, USA, SWIFT code: CITIUS33**

**CHIPS code: 0008, ABA number: 021000089**

**2. HSBC BANK USA N.A, NEW YORK, USA, SWIFT code: MRMDUS33**

**CHIPS code: 0108, ABA number: 021001088**

**3. STANDARD CHARTERED BANK, NEW YORK, USA**

**SWIFT code: SCBLUS33, CHIPS code: 0256, ABA number: 026002561**

## **Захиалга өгөх**

Харилцагч та арилжааны өмнө болон арилжааны дундуур захиалга өгөх боломжтой. Монголын хөрөнгийн биржийн арилжаа Даваа-Баасан гарагийн хооронд 10-13 цагийн хооронд явагддаг. Та өөрийн захиалгаа бидэнд маягтын дагуу бөглөж [trading@ardcapital.mn](mailto:trading@ardcapital.mn) болон [miigaa@ardcapital.mn](mailto:miigaa@ardcapital.mn) хаягуудруу цахим шуудангаар явуулна уу. Манай компанийн брокерийн үйлчилгээний шимтгэл нь 2,5% бөгөөд үүнд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн төлбөр тооцоо хадгаламжийн төв зэрэг байгуулагуудын зохицуулалт болон үйлчилгээний шимтгэлүүд багтсан байдаг. Харилцагч таны захиалга биелэгдсэний дараагаар бид танд дансны хуулгыг гаргаж өгнө.

## **Данснаасаа мөнгө гаргаж авах**

Таны мөнгө ХХБ дээрх таны үнэт цаасны төлбөр тооцооны данс дээр байршиж байх бөгөөд данснаасаа мөнгө гаргаж авахын тулд та бидэн дээр мөнгө хүсэх өргөдөл маягтын дагуу бөглөж өгснөөр данснаасаа бэлэн мөнгөний зарлага хийх боломжтой болно.

